# МОНГОЛ УЛСЫН НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

1995 оны 5 дугаар сарын 4 өдөр

Дугаар А/107

Улаанбаатар хот

Дүрэм батлах тухай

I.Монгол улсын Засгийн газрын I99I оны I70, 352 дугаар тогтоолуудыг үндэслэн "Улаанбаатар хотын Ус сувгийн ашиглалтын газрын дүрэм"-ийг хавсралтаар батлсугай.

2.Энэ захирамж гарсантай холбогдуулан Улаанбаатар хотын Ардын хурлын гүйцэтгэх захиргааны "Улсын үйлдвэрийн газар байгуулах тухай" I99I оны 342 дугаар тогтоолын 2 дугаар зүйлийг хүчингүй болсонд тооцсугай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА<br>БӨГӨӨД УЛААНБААТАР<br>ХОТЫН ЗАХИРАГЧ Ц.БААСАНЖАВ

Нийслэлийн Засаг даргын 1995 оны 5 дугаар сарын 4-ний А/107 дугаар захирамжийн хавсралт

# УЛААНБААТАР ХОТЫН УС СУВГИЙН АШИГЛАЛТЫН ГАЗРЫН ДҮРЭМ

## Нэг. Нийтлэг үндэслэл

1.Улаанбаатар хотын Ус сувгийн ашиглалтын газар /цаашид газар гэнэ/-ын үндсэн зорилт нь Нийслэл хотын хүн ам, үйлдвэр аж ахуй, соёл үйлчилгээний газруудыг унд-ахуйн стандартын шаардлагад тохирсон цэвэр усаар тасралтгүй хангаж, гарсан бохир усыг татан зайлуулж цэвэрлэхэд оршино.

2.Газар үйл ажиллагаандаа Монгол улсын хууль тогтоомж Засгийн газар, Нийслэлийн засаг даргын тогтоол шийдвэр, энэ дүрэм болон холбогдох эрх зүйн актыг дагаж мөрдөнө.

3.Газар нь хэрэглэгчдийг цэвэр усаар хангаж бохир усыг нь татан зайлуулж үйлчилгээний хөлс авах бөгөөд мэргэжлийн ажлын дагуу төлбөрт үйлчилгээ явуулж гадаад дотоод худалдаа хийх цайны газар ажиллуулан орлогоороо зардлаа нөхөж аж ахуйн сүрэн тооцооны үндсэн дээр бие даан ажиллана. Үйл ажиллагаатайгаа холбогдсон үүргийг эд хөрөнгөөрөө хариуцна.

4.Газрыг Нийслэлийн Засаг дарга өөрчлөн байгуулж, татан буулгана.

5.Газар улсын бүртгэлд бүртгүүлж гэрчилгээ авч үйл ажиллагаагаа явуулна.

6.Газар зөвлөлийн гишүүдтэй байна. Зөвлөлийн гишүүд нь газрын даргад зөвлөх эрхтэй байх бөгөөд тэднийг газрын дарга томилно.

7.Газрын дүрмийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан Монгол улсын хууль тогтоомж, Засгийн газрын тогтоол шийдвэр эрх зүйн бусад актад нийцүүлэн тушаал, заавар гаргана. Тушаал, зааврыг ус сувгийн ашиглалтын газрын нийт ажилтан дагаж мөрдөнө.

8.Нийслэлийн Засаг дарга газрын даргатай тохиролцсоны үндсэн дээр үндсэн сангийн элэгдэл хорогдлын шимтгэлийн зарим хэсгийг төвлөрүүлж зарцуулах эрхтэй.

9.Газрын санхүү, аж ахуйн үйл ажиллагааг төрийн эрх бүхий байгууллага хянаж шалгана.

10.Газар тогтоосон журмын дагуу тэмдэг албан бичгийн хэвлэмэл хуудас хэрэглэнэ.

11.Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй, Монгол улсын хууль тогтоомж, Засгийн газрын тогтоол шийдвэрийг зөрчсөн нөхцөлд Газар хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээнэ.

12.Үйлдвэрлэл, шинжлэх ухаан техник, нийгмийн хөгжил, материал-техникийн хангамжийн асуудлыг шийдвэрлэх боломжийг өргөтгөх, ажил үйлчилгээний хэмжээг нэмэгдүүлэх зорилгоор сайн дурын үндсэн дээр үйлдвэрийн нэгдэл, концерныг бусад байгууллагатай хамтран байгуулах тухай хүсэлтээ Газар нь Нийслэлийн Засаг даргын тамгын газарт гаргана.

13.Эрх бүхий удирдах байгууллага нь Газрын бие даан ажиллах нөхцлийг бүрдүүлэх болон Монгол улсын хууль тогтоомж, бусад эрх зүйн актад заасан эрх хэмжээний дагуу заалт, шийдвэр өгнө.

## II.Газрын үүрэг

14.Нийслэлийн ус хэрэглэгчдийн хэрэгцээг байнгын тасралтгүй унд-ахуйн стандартын шаардлагад тохирсон усаар хангаж, бохирдсон усыг зохих технологийн дагуу цэвэрлэж зайлуулна.

15.Хэрэглэгчдийн усны алдагдлыг арилгах, усны бохирдолтын хэмжээнд хяналт тавих эрх бүхий улсын байцаагч, лаборатори ажиллуулж зөрчлийг арилгуулж системийн найдвертай ажиллагааг хангах арга хэмжээ авна.

16.Усны чанар, цэвэрлэгээний түвшингийн шаардлагыг газар бүрэн хариуцах бөгөөд системийн хөгжлийн хэтийн төлөв, түүнийг хэрэгжүүлэх жилийн төлөвлөгөөтэй ажиллана.

17.Санхүү, статистикийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас тогтоосон журмын дагуу анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийг хөтөлж тооцоо тайлан тэнцэл гаргаж харилцагч санхүүгийн байгууллагад өгч байна.

18.Бусад өмчлөгчдөд төрийн өмчийн эд хөрөнгийг үнэгүйгээр олгохгүй, зээл өгөхгүй.

19.Ажиллагчдын боловсрол, мэдлэг, мэргэжлийг дээшлүүлэх, давтан бэлтгэх, гэрээ захиалгын үндсэн дээр өөрийн зардлаар боловсон хүчин бэлтгэнэ.

20.Хөдөлмөр материалын норм, нормативыг тогтоож мөрдөнө.

III.Газрын эрх

21.Цэг салбарын ажиллагчдын тоо, мэргэжлийн бүрэлдэхүүнийг тогтоох, удирдлагын аппаратын цалингийн санг Нийслэлийн Засаг даргын тамгын газраар тогтоолгосны үндсэн дээр аппаратын бүтэц орон тоог тогтооно.Салбар байгууллага байгуулж дүрмийг батлах, татан буулгаж болно.

22.Орон нутгийн төсөвт татвар төлсний дараа өөрийн мэдэлд үлдэх хөрөнгийг хөдөлмөрийн хөлс, нийгмийн хөгжлийн болон үйлдвэрлэлийг өргөтгөж хөгжүүлэх сан болон бусад арга хэмжээнд зарцуулна.

23.Хөдөлмөрийн хөлс, нийгмийн хөгжлийн сан байгуулах, хуваарилах, зарцуулах журмыг хамтын гэрээнд тусгаж батлана.

24.Ажлын эцсийн үр дүнтэй уялдуулан хөдөлмөрийн хөлсийг тогтоох, шагнаж урамшуулах журмыг мөрдөнө.

25.Өндөр настан, гачигдалд байгаа ажилтнуудад тэтгэврийн нэмэгдэл, буцалтгүй тусламж олгох нөхцөл хэмжээ, журмыг тогтооно.

26.Үйлдвэрлэлийг өргөтгөх, шинэчлэн тоноглох арга хэмжээний зураг төсвийг хянаж батлана.

27.Ажил мэргэжлийн зөвлөлгөө, засвар үйлчилгээний үнэ тарифыг тогтооно.

28.Монгол улсын Засгийн газраас тогтоосон журмын дагуу үндсэн сангийн элэгдэл хорогдлын шимтгэл байгуулж зарцуулна.

29.Тогтоосон журмын дагуу гадаад худалдааны үйл ажиллагаа явуулна.

30.Барилга байгууламж, тоног төхөөрөмжийг Нийслэлийн Засаг даргын тамгын газрын зөвшөөрлөөр бусдад худалдах, шилжүүлэх буюу

дансаас хасна.

31.Хөдөлмөрийн амжилт гаргасан ажилтныг шагнаж урамшуулах тухай саналаа тогтоосон журмын дагуу дээд байгууллагад уламжилна.

32.Ажиллагсадын орон сууц, соёл ахуйн нөхцлийг системтэй сайжруулж орон сууц, биеийн тамир спортын болон соёл ахуйн барилга байгууламжийг зориулалтын сангийн хөрөнгийн хэмжээнд багтаан барьж ергөтгөж байна.

—— o O o ——